



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ ХХК-ИЙН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/38/СТА-ТӨҮГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Аудитын код: САГ-2018/38/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор О.Баярмаа
Утас: 261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn

“Мэжик консалтинг аудит” ХХК
Гүйцэтгэх захирал С.Мөнхбаяр
Аудитын менежер Г.Мөнхбаяр
Утас 70131044 Цахим хаяг: info@magicgroup.mn

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Улаанбаатар хот

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ.....	0
2	Аудитын тайлан.....	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	3
2.5	Дотоод хяналт.....	4
2.6	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	4
2.7	Шилэн дансны мэдээлэл.....	5
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	6
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	6
2.9.1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг.....	6
2.9.2	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө.....	6
2.9.3	Бараа материал.....	7
2.9.4	Үндсэн хөрөнгө.....	7
2.9.5	Худалдан авах ажиллагаа.....	8
2.9.6	Хувь хүнээс худалдан авсан бараа, ажил үйлчилгээ.....	8
2.9.7	Дараа тайлан.....	9
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	9
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	9
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	10
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	10
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал.....	12
3.1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг.....	13
3.2	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө.....	15
3.3	Бараа материал.....	16
3.4	Үндсэн хөрөнгө.....	17
3.5	Худалдан авах ажиллагаа.....	18
3.6	Хувь хүнээс худалдан авсан бараа, ажил үйлчилгээ.....	19
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, эдийн засгийн төлөвлөгөөний гүйцэтгэл.....	20
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	20
4.2	Аудит хийгдсэн орлого үр дүнгийн тайлан.....	21
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	22
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	22
4.5	Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэл.....	23

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ч.ЗОЛБАЯР ТАНАА

2018.03.15 № 06/687
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**



Үүрэг, хариуцлага

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ



2 Аудитын тайлан

2.1 Оршил

Мэдээдэл холбооны сүлжээ ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Н.Мягмарсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах, мөнгөн хөрөнгийн зарцуулалтын журмыг дагаж мөрдөх, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцдог байх, бараа материалыг салбар хооронд шилжүүлэхдээ шаардах хуудас бичдэг байх, үндсэн хөрөнгийг бүрэн кодлох, төлөвлөгөөнд ороогүй бараа, ажил үйлчилгээг худалдан авахгүй байх, хувь хүнээс бараа, ажил үйлчилгээ худалдан авч, ХХОАТ-ыг суутгаагүй тохиолдолд Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан орлогын албан татварын тайлангийн 2 дугаар хавсралтаар буюу суутгаагүй олгосон орлогоор тайлагнаж байх, дараа тайлангаар бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа НӨАТ-ын баримтыг компанийн нэр дээр авч байх зөвлөмжүүдийг тусгаж, үндсэн хөрөнгийн 2017 оны жилийн эцсийн тооллогын үр дүнгээр үүссэн үндсэн хөрөнгийн дутагдлыг барагдуулах арга хэмжээ авах тухай албан шаардлага хүргүүлсэн болно.


Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/ ийн аудитийн байгууллага гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв шуударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.



Гүйцэтгэх удирдлага нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн байгууллагын санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 1-нээс 2018 оны 3 дугаар сарын 10-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 12-нд эцэслэн баталгаажуулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад хүргүүлэхээр төлөвлөн, Мэжик консалтинг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Мөнхбаяр, аудитын менежер Г.Мөнхбаяр, аудитор Н.Мандах, Ц.Гүнсэнмаа, аудиторын туслах Д.Наранбат нар хариуцаж хэрэгжүүлэв.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 10-ны өдөр Мэжик консалтинг аудит ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”, 2014 оны 249 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Харилцаа холбооны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Компанийн тухай, Татварын ерөнхий, Нийгмийн даатгалын тухай, Төрийн аудитын тухай, Аудитын тухай, Шилэн дансны тухай, Иргэний, Хөдөлмөрийн тухай, Архивын тухай, Аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль тогтоомжид өөрчлөлт ороогүй.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь Монгол улсын нутаг дэвсгэрийг хамарсан мэдээлэл холбооны үндсэн сүлжээ болон улс, хот хооронд, орон нутгийн дамжуулах байгууламжийн нэгдсэн сүлжээг эзэмшин, тэдгээрийн байнгын тасралтгүй ажиллагааг хангаж, ашиглалт үйлчилгээг хариуцдаг, 100 хувь төрийн өмчит компани юм.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь мэдээлэл холбооны үндсэн сүлжээ, дэд бүтэц байгуулах, эзэмших, ашиглах 403/A/ICN 01 тоот тусгай зөвшөөрөл эзэмшдэг ба уг зөвшөөрлийн хүрээнд:

- Монгол улсын нутаг дэвсгэрт мэдээлэл холбооны сүлжээ, дэд бүтэц байгуулах, эзэмших, ашиглах,
- Монгол улсын нутаг дэвсгэрт улс хоорондын түрээслүүлэх үйлчилгээ эрхлэн үйл ажиллагаа явуулдаг байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

Монгол улсын нутаг дэвсгэрийг хамарсан мэдээлэл, холбооны үндсэн сүлжээ болох улс, хот хооронд, орон нутгийн дамжуулах байгууламжийн нэгдсэн сүлжээг эзэмшин, тэдгээрийн байнгын тасралтгүй ажиллагааг хангах, ашиглалт үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэн явуулж байна.

Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Компанийн 2021 он хүртэлх дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хүрээнд үндсэн сүлжээний багтаамжийг нэмэгдүүлж, үнэ тарифын бодлогоо бүрэн шинэчлэн, компани, харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгч компаниуд, эцсийн хэрэглэгч бүгдэд харилцан ашигтай байх бизнесийн загварыг нэвтрүүлэн компанийг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх зорилготой байна.

Дээрх зорилгын хүрээнд дараахь зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

- Дотоодын зах зээлийг бүрэн хангахуйц үндсэн сүлжээний багтаамжтай болох,
- Олон улсын бизнесийг өргөжүүлж, интернэтийн бөөний урсгалын тарифыг зах зээлд бодитоор тогтоох,
- Компанийн хүний нөөцийн боломж дээр суурилан бусад компаниудын техникийн ашиглалт үйлчилгээг хариуцсан техникийн хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 8 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 31 горим, сорил гүйцэтгэв.

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгов.

Нийт зардлын дүнгээс материаллаг түвшинг сонгон авсан шалтгаан нь компанийн 2016 он, 2017 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг харьцуулахад орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого, нийт зардал, санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх онтой харьцуулахад 1-8 хувиар өссөн харин санхүүгийн байдлын тайлангийн цэвэр хөрөнгө 72 хувиар өссөн байна. Иймд хэлбэлзлийн түвшин дундаж байгаа үзүүлэлт буюу 2017 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг суурь болгон сонгож авав.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2017 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 33,290.7 сая төгрөг бөгөөд 1.0 хувиар буюу 332.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. /ТАБ-СТА-В-1/

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн "Юникус" програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан журмын 1 дүгээр зүйлийн 1.3-т "Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журамтай байна" гэж заасантай нийцүүлэн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2017 оны 01-р сарын 12-ны өдрийн А/05 тоот тушаалаар баталсан "Дотоод хяналтыг зохион байгуулах журам"-ын дагуу дотоод хяналтын алба гүйцэтгэж байна.

Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.2-т заасны дагуу компанийн Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нар өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутмын хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалттай гэж үзлээ.

2.6 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 316 дугаар тогтоолоор Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2017 оны "Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө"-г баталсан байна.

Батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Орлогын гүйцэтгэл:

Худаг, сувагчлалын түрээсийн орлого, улс хоорондын сүлжээний орлого, хэрэглэгчийн шугамын, техник менежментийн үйлчилгээний орлого, байр талбай, антенны түрээсийн орлого нийт 33,946.2 сая төгрөг, бусад үйл ажиллагааны бусад орлого 1,519.2 сая төгрөг, нийт 2017 оны орлогын дэлгэрэнгүй тайлангаар 35,465.4 сая төгрөгийн орлоготой ажиллаж, орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онд үүсгэж харьцуулахад 5.3 хувиар буюу 1,795.5 сая төгрөгөөр, төлөвлөгөөтэй харьцуулахад 2.3 хувиар буюу 811.0 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

01
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
СНАЛ ДҮННЭЛТ

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

Зардлын гүйцэтгэл:

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг 28,550.6 сая төгрөг, ерөнхий ба удирдлагын зардал 2,763.0 сая төгрөг, борлуулалт маркетингийн зардал 300.0 сая төгрөг, бусад зардал 1,294.2 сая төгрөг нийт 32,907.8 сая төгрөгийн зардалтай ажиллаж, зардлын гүйцэтгэлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7.4 хувь буюу 2,277.6 сая төгрөгөөр, төлөвлөгөөтэй харьцуулахад 0.8 хувиар буюу 255.2 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Ашиглалтын зардал болон нийт орлого өссөн гол шалтгаан нь Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь 2017 оноос эхлэн үүрэн телефоны гурван оператор компаниудад (Юнител ХХК, Скайтел ХХК, Жи Мобайл ХХК) техникийн гэмтэл засварын ажил гүйцэтгэх аутсорсингийн гэрээ байгуулж ажиллаж байгаатай холбоотой юм.

Үр дүн цэвэр ашиг: Тайлант онд 2,147.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, цэвэр ашгийн төлөвлөгөөг 26.2 хувиар буюу 445.2 сая төгрөгөөр давуулан биелүүлж борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал 0.93 төгрөг болж, төлөвлөгөөг 1.5 хувиар буюу 0.01 төгрөгөөр бууруулсан байна.

Авлага, өглөг: Өмнөх оны мөн үеэс богино хугацаатай авлага 178.1 сая төгрөгөөр буурч, богино хугацаат өр төлбөр 282.2 сая төгрөгөөр өссөн байна.

Урьдчилж төлсөн зардал/тооцоо: Өмнөх оны мөн үеэс урьдчилж төлсөн зардал/тооцоо 1,298.5 сая төгрөгөөр өссөн байна.

Урьдчилж төлсөн тооцоо/зардал өссөн шалтгаан нь Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь 2017 оноос эхлэн орон нутгийн хэмжээнд 10G, 100G сүлжээний өргөтгөлийн ажил хийгдэж байгаатай холбоотой бөгөөд уг өргөтгөлийн ажил 2018 онд бүрэн хийгдэж дуусах юм.


Сүлжээний өргөтгөлийн тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах ажил нь ТӨБЗГ-аас баталсан “2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалт” болон ТУЗ-өөс баталсан 2017 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан байна.

Эзний өмчийн бусад хэсэг: Тайлант онд эзний өмчийн бусад хэсэг данс 1,347.7 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн “Сумдад интернетийн үйлчилгээ хүргэхэд шаардагдах хандалтын үндсэн тоног төхөөрөмж нийлүүлэх суурилуулах” төслийн хөрөнгийг Мэдээлэл технологи харилцаа холбооны газраас шилжүүлж авсан бөгөөд уг хөрөнгийг бүртгэж авах тухай ТӨБЗГ-ын 2017 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн А-5/1019 тоот зөвшөөрлийн дагуу эзний өмчийн бусад хэсэгт бүртгэсэн байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Байгууллагын цахим хуудас www.netcom.mn сайтад шилэн дансны цэсийг холбосон Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын тухайн жилийн төлөвлөгөө, гүйцэтгэл, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, нийлүүлэгчийн мэдээлэл болон 2017 оны худалдан авах ажиллагааны тайланг оруулсан байна.



2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 31 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны "Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах" гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/126 дугаар тушаалаар батлан мөрдөж байна. 2016 оноос хойш Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх дараах стандартуудын өөрчлөлттэй холбоотой Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулаагүй байна.

- СТОУС-14 Хуулийн шаардлагаар хойшлуулсан данс (Regulatory deferral account)
- СТОУС-15 Худалдан авагчтай хийсэн гэрээний орлого (Revenue from Contract with Customers)
- СТОУС-16 Түрээс (Leases)

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 8 "Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон алдаа, тооцооллын өөрчлөлт"-ийн 8 дугаар зүйлийн 8.14-т дараах тохиолдолд аж ахуйн нэгж бүртгэлийн бодлогоо өөрчилж болно. Үүнд:

- a) "Аль нэг СТОУС-аар өөрчлөлт орж, шаардсаны улмаас"
- b) "Аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл эсвэл мөнгөн гүйлгээнд үзүүлэх ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөний талаар илүү найдвартай бөгөөд хамааралтай мэдээлэл санхүүгийн тайланд бий болж байвал"
гэсэн стандартын шаардлагад нийцүүлж нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн боловсруулах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх.

2.9.2 Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

- Дараа тайлангаар олгох бэлэн мөнгөний дээд хэмжээг хэтрүүлсэн зөрчил гаргасан байна. Үүнд Төв компанийн касс 11 удаа, Архангай аймаг 6 удаа, Баянхонгор аймаг 1 удаа, Булган аймаг 5 удаа, Дархан-Уул аймаг 7 удаа, Дорнод аймаг 6 удаа, Дундговь аймаг 1 удаа, Өмнөговь аймаг 2 удаа, Сэлэнгэ аймаг 5 удаа, Хэнтий аймаг 2 удаа, нийт 46 удаагийн 50.7 сая төгрөгөөр дараа тайланг олгох дээд хязгаараас хэтрүүлсэн байна.

Энэ нь Гүйцэтгэх захирлын 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/126 тоот тушаалаар баталсан кассын ажиллагааны журамд "Шаардлагатай тохиолдолд ажилтан албан хаагчдад дараа тайлангаар бэлэн мөнгө олгож болно, дараа

50.7 сая төгрөгөөр дараа тайланг олгох дээд хязгаараас хэтрүүлсэн байна.

01 ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ

тайлангаар олгох бэлэн мөнгөний дээд хэмжээ Улаанбаатар төв салбар 5.0 сая төгрөг, орон нутгийн салбар газарт 0.5 сая төгрөгөөс хэтрэхгүй байна” гэж заасан заалтыг дагаж мөрдөөгүй байна.

- Улаанбаатар төв салбар болон орон нутгийн кассын сарын эцсийн үлдэгдэл байх ёстой хэмжээнээс хэтэрсэн зөрчил гаргасан байна. Үүнд Төв компанийн касс 4, 6, 7, 11-р сар, Үндсэн сүлжээний газар 1-р сар, Архангай аймаг 1, 4, 11-р сар, Багануур дүүрэг 6, 12-р сар, Баянхонгор аймаг 1, 3, 4, 5, 6, 8, 9, 12-р сар, Булган аймаг 4, 8-р сар, Дорноговь аймаг 7-р сар, Дорнод аймаг 1, 4, 5, 7, 8, 9-р сар, Завхан аймаг 2, 3, 4, 5, 6, 7, 8, 10-р сар, Өвөрхангай аймаг 5-р сар Өмнөговь аймаг 2-р сар, Төв аймаг 4, 5, 6, 12-р сар, Увс аймаг 4, 7-р сар, Ховд аймаг 1-р сар, Хөвсгөл аймаг 2, 3-р сар Хэнтий аймаг 12-р сар нийт 47 удаагийн кассын үлдэгдлийг лимитээс 83.6 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Энэ нь Гүйцэтгэх захирлын 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/126 тоот тушаалаар баталсан кассын ажиллагааны журамд "Кассын сар бүрийн эцэс дэх бэлэн мөнгөний үлдэгдлийн хэмжээ нь төв компанийн касс 10.0 сая төгрөг, салбарт 0.2 сая төгрөгөөс хэтрэхгүй байна гэж заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Гүйцэтгэх захирлын 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/126 тоот тушаалаар баталсан "Кассын ажиллагааны журам"-ыг дагаж мөрдөх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх.

2.9.3 Бараа материал

Төв салбараас орон нутаг руу 321.5 сая төгрөгийн бараа материал шилжүүлэхдээ шаардах хуудас бичээгүй зөрчил гаргасан байна.

Энэ нь гүйцэтгэх захирлын 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/128 тоот тушаалаар баталсан "Бараа материал бүртгэлийн журам"-ийн 3 дугаар зүйлийн 3.7-д "Эд хариуцагч бараа материалын зарлагын баримт, шаардах хуудас, бусад дэмжих баримтыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгоно, мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг тус тус дагаж мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалыг салбар хооронд шилжүүлэхдээ гүйцэтгэх захирлын 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/128 тоот тушаалаар баталсан "Бараа материал бүртгэлийн журам"-ийн дагуу анхан шатны баримтуудыг үйлдэж байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг дагаж мөрдөхийг менежментийн захидлаар зөвлөмж өгөх.

2.9.4 Үндсэн хөрөнгө

- Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2017 оны 11-р сарын 30-ны А/166 тоот тушаалаар үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллого хийгдсэн. Тооллогоор 11.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө дутагдсан бөгөөд тооллогын үр дүнг тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ

ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ" гэж заасныг тус, тус дагаж мөрдөөгүй байна.

- Улаанбаатар хотод байрлах үндсэн хөрөнгөөс 52% буюу 33,936.0 сая төгрөгийн өртөг бүхий 112 хөрөнгийг түүвэрлэн тоолоход үндсэн хөрөнгө кодгүй, код зөрүүтэй зөрчил илэрсэн.

Энэ нь гүйцэтгэх захирлын 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/127 тоот тушаалаар баталсан үндсэн хөрөнгийн бүртгэлийн журамд "Үндсэн хөрөнгийн бүртгэл нь 10 орон бүхий кодоор дугаарласан байна. Мөн компани бүх үндсэн хөрөнгийг кодчиллын дагуу дугаарлаж бүртгэх ба хөрөнгийн аль нэг нүдэнд харагдахуйц, харж тулгаж болохуйц газарт, мөн нэг хөрөнгийн иж бүрдэл хэсгүүдэд тухайн хөрөнгийн дугаарыг хэвлэмэл хэлбэрээр нааж дугаарласан байна" гэж заасныг биелүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

- Тооллогын үр дүнгээр дутагдсан хөрөнгүүдийн зах зээлийн үнийг тогтоож, хариуцаж ажиллаж байсан эд хариуцагчдад авлага үүсгэж бүртгэх, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх албан шаардлага өгөх.
- Гүйцэтгэх захирлын 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/127 тоот тушаалын 2 дугаар хавсралт "Үндсэн хөрөнгийн бүртгэл"-ийн дагуу бүртгэлжүүлэх, коджуулах ажлыг зохион байгуулахыг менежментийн захидлаар зөвлөмж өгөх.

2.9.5 Худалдан авах ажиллагаа

Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газрын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 316 тоот тогтоолоор баталсан "2017 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө"-нд үндэслэн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 61/02 тоот тогтоолоор 2017 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг баталсан. Уг худалдан авах төлөвлөгөөнд ороогүй нийт 42.6 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авсан байна. Үүнд:



- АТС-36 барилгын дээврийн засварын ажлыг Ихэр түрүү ХХК-аар 23.9 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн;
- УБ-Эмээлт-Төв-Алтанбулаг сум-Лүн сумын чиглэлийн кабелийн засварын ажлыг Хориулт ХХК-аар 18.7 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 61/02 тоот тогтоолыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газрын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 316 тоот тогтоолын дагуу баталсан ТУЗ-ийн тогтоолыг дагаж мөрдөх, зайлшгүй худалдан авах шаардлагатай тохиолдолд ТУЗ-өөс тодотголоор батлуулж байхыг менежментийн захидлаар зөвлөмж өгөх.

2.9.6 Хувь хүнээс худалдан авсан бараа, ажил үйлчилгээ

Зардлын түүвэр шалгалтаар иргэн Д.Батцэцэг, Ц.Хишигжаргал нараас нийт 4.1 сая төгрөгийн худалдан авалт хийсэн. Уг худалдан авалтаас хувь хүний орлогын албан татварыг суутгаж аваагүй, мөн ТТ 12(2) маягтаар тайлагнаагүй байна.



Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-д “Суутгагч нь иргэнд орлого олгох бүрдээ түүний татвар төлөгчийн дугаарыг орлого олгосон тухай баримтад тэмдэглэж, иргэн бүрт олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээг тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж мэдэгдэх” ёстой гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хэрэв иргэн, хувь хүнд суутгаагүй орлого олгосон тохиолдолд ХХОАТ-ын тайланд ТТ-12(2) маягтаар тайлагнахыг менежментийн зөвлөмжөөр зөвлөмж өгөх.

2.9.7 Дараа тайлан

Дараа тайлангаар бараа материал худалдан авалт хийж, тайланг хаахдаа хувь хүний сугалааны дугаартай нэмэгдсэн өртгийн албан татварын баримт бүхий 15.3 сая төгрөгийн анхан шатны баримт бүрдүүлэн, ААНОАТ-ын тайланд татвар ногдох орлогоос хасагдах зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1.2-д “Албан татвар төлөгчийн баримтаар нотлогдоогүй зардал нь албан татвар төлөгчийн татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцогдохгүй” гэж заасныг зөрчиж, мөн 1.4 сая төгрөгийг нэмэгдсэн өртгийн албан татварын өглөгөөс хасагдуулга хийх боломжийг алдсан байна.

Шийдвэрлэсэн нь: Дараа тайланг хаахдаа хувь хүний сугалааны дугаартай болон хүчин төгөлдөр бус баримттай тохиолдолд тухайн ажилтанд хариуцлага тооцдог байх, дараагийн тайланг үүсгэхгүй байх зэрэг хяналтын арга хэмжээ авч ажиллах, цаашид хувь хүний сугалааны дугаартай баримтаар ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгахгүй байх талаар албан шаардлага өгөх.

2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар компанийн бүртгэлгүй болон төслүүдээс хүлээн авсан хөрөнгүүдийг бүртгэлжүүлсэн эсэх, нийт хөрөнгийн үнэлгээг бүрэн гүйцэд хийсэн эсэх, үл хөдлөх хөрөнгүүдийг улсын бүртгэлийн гэрчилгээжүүлэх ажил хийгдсэн эсэхийг шалгах.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 529.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 26.7 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 502.6 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 6 зөвлөмж өгөгдсөн байна. Өгөгдсөн 4 зөвлөмжийг бүрэн биелүүлж, 1 зөвлөмжийг 60 хувь, 1 зөвлөмжийг 97 хувь биелүүлж, 1 зөвлөмжийн биелэлт 93 хувьтай байна.

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

ТОРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Мэдээдэл холбооны сүлжээ ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**



<p>3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын БАРИМТ БИЧИГ</p>	<p>Тэргүүлэх ач холбогдол №1</p>
--	---

ҮАГ-ын ажиглалт

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2015 оны 12 дугаар сарын 28 өдрийн А/126 тоот тушаалаар батлан мөрдөж байна. 2016 оноос хойш Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх дараах стандартуудын өөрчлөлттэй холбоотой Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулаагүй байна.

- СТОУС-14 Хуулийн шаардлагаар хойшлуулсан данс (Regulatory deferral account)
- СТОУС-15 Худалдан авагчтай хийсэн гэрээний орлого (Revenue from Contract with Customers)
- СТОУС-16 Түрээс (Leases)

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 8 “Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон алдаа, тооцооллын өөрчлөлт”-ийн 8 дугаар зүйлийн 8.14-т дараах тохиолдолд аж ахуйн нэгж бүртгэлийн бодлогоо өөрчилж болно. Үүнд:

- с) “Аль нэг СТОУС-аар өөрчлөлт орж, шаардсаны улмаас”
- д) “Аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл эсвэл мөнгөн гүйлгээнд үзүүлэх ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөний талаар илүү найдвартай бөгөөд хамааралтай мэдээлэл санхүүгийн тайланд бий болж байвал”

гэсэн стандартын шаардлагад нийцүүлж нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулаагүй байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалт зөрчигдөх, Холбогдох стандартын өөрчлөлтийг дагаж мөрдөж чадахгүй байх, Санхүүгийн тайлангийн үнэн зөв батламж мэдэгдэл хангахгүй байх;


ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж батлах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 10 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.



3.2 Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө**Тэргүүлэх ач холбогдол №2****ҮАГ-ын ажиглалт**

- Дараа тайлангаар олгох бэлэн мөнгөний дээд хэмжээг хэтрүүлсэн зөрчил гаргасан байна. Үүнд Төв компанийн касс 11 удаа, Архангай аймаг 6 удаа, Баянхонгор аймаг 1 удаа, Булган аймаг 5 удаа, Дархан-Уул аймаг 7 удаа, Дорнод аймаг 6 удаа, Дундговь аймаг 1 удаа, Өмнөговь аймаг 2 удаа, Сэлэнгэ аймаг 5 удаа, Хэнтий аймаг 2 удаа, нийт 46 удаагийн 50.7 сая төгрөгөөр дараа тайланг олгох дээд хязгаараас хэтрүүлсэн байна.

Энэ нь Гүйцэтгэх захирлын 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/126 тоот тушаалаар баталсан кассын ажиллагааны журамд "Шаардлагатай тохиолдолд ажилтан албан хаагчдад дараа тайлангаар бэлэн мөнгө олгож болно, дараа тайлангаар олгох бэлэн мөнгөний дээд хэмжээ Улаанбаатар төв салбар 5.0 сая төгрөг, орон нутгийн салбар газарт 0.5 сая төгрөгөөс хэтрэхгүй байна" гэж заасан заалтыг дагаж мөрдөөгүй байна.

- Улаанбаатар төв салбар болон орон нутгийн кассын сарын эцсийн үлдэгдэл байх ёстой хэмжээнээс хэтэрсэн зөрчил гаргасан байна. Үүнд Төв компанийн касс 4, 6, 7, 11-р сар, Үндсэн сүлжээний газар 1-р сар, Архангай аймаг 1, 4, 11-р сар, Багануур 6, 12-р сар, Баянхонгор аймаг 1, 3, 4, 5, 6, 8, 9, 12-р сар, Булган аймаг 4, 8-р сар, Дорноговь аймаг 7-р сар, Дорнод аймаг 1, 4, 5, 7, 8, 9-р сар, Завхан аймаг 2, 3, 4, 5, 6, 7, 8, 10-р сар, Өвөрхангай аймаг 5-р сар Өмнөговь аймаг 2-р сар, Төв аймаг 4, 5, 6, 12-р сар, Увс аймаг 4, 7-р сар, Ховд аймаг 1-р сар, Хөвсгөл аймаг 2, 3-р сар Хэнтий аймаг 12-р сар нийт 47 удаагийн кассын үлдэгдлийг лимитээс 83.6 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Энэ нь Гүйцэтгэх захирлын 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/126 тоот тушаалаар баталсан кассын ажиллагааны журамд "Кассын сар бүрийн эцэс дэх бэлэн мөнгөний үлдэгдлийн хэмжээ нь төв компанийн касс 10.0 сая

ҮАГ-ын зөвлөмж

Гүйцэтгэх захирлын 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/126 тоот тушаалаар баталсан "Кассын ажиллагааны журам"-ыг дагаж мөрдөх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 10 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

төгрөг, салбарт 0.2 сая төгрөгөөс хэтрэхгүй байна гэж заасныг зөрчиж байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан заалтуудыг зөрчих

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.3 БАРАА МАТЕРИАЛ**Тэргүүлэх ач холбогдол №3****ҮАГ-ын ажиглалт**

Төв салбараас орон нутаг руу 321.5 сая төгрөгийн бараа материал шилжүүлэхдээ шаардах хуудас бичээгүй зөрчил гаргасан байна.

Энэ нь гүйцэтгэх захирлын 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/128 тоот тушаалаар баталсан “Бараа материал бүртгэлийн журам”-ийн 3 дугаар зүйлийн 3.7-д “Эд хариуцагч бараа материалын зарлагын баримт, шаардах хуудас, бусад дэмжих баримтыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгоно, мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус дагаж мөрдөөгүй байна.

Эрсдэлүүд

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг дагаж мөрдөхгүй байх,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөхгүй байх;

ҮАГ-ын зөвлөмж

Бараа материалыг салбар хооронд шилжүүлэхдээ гүйцэтгэх захирлын 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/128 тоот тушаалаар баталсан “Бараа материал бүртгэлийн журам”-ийн дагуу анхан шатны баримтуудыг үйлдэж байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг дагаж мөрдөх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 10 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ****01**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.4 Үндсэн хөрөнгө

Тэргүүлэх ач холбогдол №4

ҮАГ-ын ажиглалт

Улаанбаатар хотод байрлах үндсэн хөрөнгөөс 52% буюу 33,936.0 сая төгрөгийн ертөг бүхий 112 хөрөнгийг түүвэрлэн тоолоход үндсэн хөрөнгө кодгүй, код зөрүүтэй зөрчил илэрсэн.

Энэ нь гүйцэтгэх захирлын 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/127 тоот тушаалаар баталсан үндсэн хөрөнгийн бүртгэлийн журамд "Үндсэн хөрөнгийн бүртгэл нь 10 орон бүхий кодоор дугаарласан байна. Мөн компани бүх үндсэн хөрөнгийг кодчиллын дагуу дугаарлаж бүртгэх ба хөрөнгийн аль нэг нүдэнд харагдахуйц, харж тулгаж болохуйц газарт, мөн нэг хөрөнгийн иж бүрдэл хэсгүүдэд тухайн хөрөнгийн дугаарыг хэвлэмэл хэлбэрээр нааж дугаарласан байна" гэж заасныг биелүүлээгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Гүйцэтгэх захирлын 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/127 тоот тушаалын 2 дугаар хавсралт "Үндсэн хөрөнгийн бүртгэл"-ийн дагуу бүртгэлжүүлэх, коджуулах ажлыг зохион байгуулах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 10 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг дагаж мөрдөхгүй байх;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.5 Худалдан авах ажиллагаа

Тэргүүлэх ач холбогдол №5

ҮАГ-ын ажиглалт

Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газрын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 316 тоот тогтоолоор баталсан “2017 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө”-нд үндэслэн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 61/02 тоот тогтоолоор 2017 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг баталсан. Уг худалдан авах төлөвлөгөөнд ороогүй нийт 42.6 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авсан байна. Үүнд:

- АТС-36 барилгын дээврийн засварын ажлыг Ихэр түрүү ХХК-аар 23.9 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн;
- УБ-Эмээлт-Төв-Алтанбулаг сум-Лүн сумын чиглэлийн кабелийн засварын ажлыг Хориулт ХХК-аар 18.7 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 61/02 тоот тогтоолыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 61/02 тоот тогтоолыг зөрчих;

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газрын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 316 тоот тогтоолын дагуу баталсан ТУЗ-ийн тогтоолыг дагаж мөрдөх, зайлшгүй худалдан авах шаардлагатай тохиолдолд ТУЗ-өөс тодотголоор батлуулж байх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 10 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.6 Хувь хүнээс худалдан авсан бараа, ажил үйлчилгээ

Тэргүүлэх ач холбогдол №6

ҮАГ-ын ажиглалт

Зардлын түүвэр шалгалтаар иргэн Д.Батцэцэг, Ц.Хишигжаргал нараас нийт 4.1 сая төгрөгийн худалдан авалт хийсэн. Уг худалдан авалтаас хувь хүний орлогын албан татварыг суутгаж аваагүй, мөн ТТ 12(2) маягтаар тайлагнаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-д "Суутгагч нь иргэнд орлого олгох бүрдээ түүний татвар төлөгчийн дугаарыг орлого олгосон тухай баримтад тэмдэглэж, иргэн бүрт олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээг тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж мэдэгдэх" ёстой гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

ХХОАТ-ын тухай хууль зөрчих;

ҮАГ-ын зөвлөмж

Хэрэв иргэн, хувь хүнд суутгаагүй орлого олгосон тохиолдолд ХХОАТ-ын тайланд ТТ-12(2) маягтаар тайлагнаж байх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 10 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		
1.1.2	Дансны авлага	12,976,885,387.10	12,748,688,224.08
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	4,292,279,254.71	3,669,892,230.23
1.1.4	Бусад авлага	94,931,715.37	159,361,711.52
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	256,259,235.88	284,931,815.96
1.1.6	Бараа материал	3,000,000,000.00	3,000,000,000.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,464,186,185.10	2,604,022,299.37
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,121,082,269.56	2,419,611,778.70
1.2.1	Үндсэн хөрөнгө	24,205,624,047.72	24,886,508,059.86
1.2.2	Биет бус хөрөнгө	63,693,899,434.78	64,068,972,959.39
1.2.3	Хойшлогдсон татварын хөрөнгө	130,967,103.94	114,249,748.92
1.2.4	Бусад эргэлтийн бус хөрөнгө	249,825,231.30	266,782,567.59
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,992,898,691.59	4,992,898,691.59
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	69,067,590,461.61	69,442,903,967.49
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	93,273,214,509.33	94,329,412,027.35
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.3	Татварын өр	635,212,663.42	788,010,434.70
2.1.1.4	НДШ-ийн өглөг	41,057,034.94	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,120,377.14	43,000.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	27,449,068.29	56,935,634.25
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	26,034,866.29	168,063,387.42
2.1.2.1	Урт хугацаат зээл	730,874,010.08	1,013,052,456.37
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	48,871,150,747.51	46,745,952,902.63
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	3,308,017,896.30	3,333,236,961.95
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	15,251,338,946.02	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	67,430,507,589.83	50,079,189,864.58
2.3	Эзэмшигчдийн өмч	68,161,381,599.91	51,092,242,320.95
2.3.1	Өмч: - төрийн	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	122,171,110,115.54	137,551,494,711.54
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	413,738,403.33	413,738,403.33
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-	1,347,724,159.68
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	(97,473,015,609.45)	(96,075,787,568.15)
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	25,111,832,909.42	43,237,169,706.40
		93,273,214,509.33	94,329,412,027.35

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.2 Аудит хийгдсэн орлого үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	32,645,421,987.75	33,946,308,076.22
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	25,092,423,836.62	28,550,613,470.69
3	Нийт ашиг (алдагдал)	7,552,998,151.13	5,395,694,605.53
5	Хүүний орлого	855,251,649.04	1,425,950,682.41
8	Бусад орлого	36,668,956.27	28,476,085.98
9	Борлуулалт, маркетингийн зардал	277,182,731.91	299,988,181.91
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,712,978,225.13	2,762,811,891.00
12	Бусад зардал	1,547,544,961.68	1,274,974,636.95
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	129,985,658.08	(3,318,074.51)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	2,660,556.15	48,593,300.04
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	3,039,859,051.95	2,557,621,889.59
19	Орлогын татварын зардал	496,630,955.45	402,351,331.44
19.1	Хойшлогдсон татварын зардал	21,923,843.91	8,261,729.36
20	Татварын дараах ашиг (алдагдал)	2,521,304,252.59	2,147,008,828.79
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	2,521,304,252.59	2,147,008,828.79
24	Орлогын нийт дүн	2,521,304,252.59	2,147,008,828.79
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	122,171,110,115.54	413,738,403.33		(99,263,973,262.96)	23,320,875,255.91
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				18,573,100.92	18,573,100.92
Залруулсан үлдэгдэл	122,171,110,115.54	413,738,403.33		(99,245,400,162.04)	23,339,448,356.83
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				2,521,304,252.59	2,521,304,252.59
Бусад дэлгэрэнгүй орлого					
Өмчид гарсан өөрчлөлт					
Зарласан ногдол ашиг	-	-	-	(748,979,700.00)	(748,979,700.00)
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	-
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	122,171,110,115.54	413,738,403.33		(97,473,015,609.45)	25,111,832,909.42
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				6,610,502.51	6,610,502.51
Залруулсан үлдэгдэл	122,171,110,115.54	413,738,403.33		(97,466,405,106.94)	25,118,443,411.93
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-			2,147,008,828.79	2,147,008,828.79
Бусад дэлгэрэнгүй орлого					
Өмчид гарсан өөрчлөлт	15,380,384,596.00		1,347,724,159.68	756,391,290.00	16,728,108,755.68
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	756,391,290.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	-
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	137,551,494,711.54	413,738,403.33	1,347,724,159.68	(96,075,787,568.15)	43,237,169,706.40

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**
САН-2018/58/СТА-ТӨҮГ

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/төгрөгөөр/	
	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	34,601,230,686.47	37,367,035,721.10
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	34,375,835,108.70	37,202,242,288.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	21,821,287.00	4,903,359.00
	Бусад мөнгөн орлого	203,574,290.77	159,890,074.10
1.2	Мөнгөн зарлага (-)	26,944,340,714.70	30,138,711,641.06
	Ажиллагчдад төлсөн	9,881,227,043.45	10,582,840,947.15
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	2,575,685,996.09	2,749,755,062.26
	Бараа материал худалдан авахад төлсөн	1,056,924,139.44	1,401,580,544.71
	Ашиглалтын зардалд төлсөн	6,648,347,013.24	7,480,209,156.21
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	660,479,072.71	812,553,704.02
	Хүүний төлбөрт төлсөн	369,167.30	1,100,313,079.15
	Татварын байгууллагад төлсөн	4,467,592,033.11	4,768,834,119.38
	Даатгалын төлбөрт төлсөн	36,163,568.65	58,186,013.00
	Бусад мөнгөн зарлага	1,617,552,680.71	1,184,439,015.18
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	7,656,889,971.77	7,228,324,080.04
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	850,709,854.52	1,420,166,722.19
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	7,513,000.00	7,437,000.00
	Хүлээн авсан хүүний орлого	843,196,854.52	1,412,729,722.19
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,646,696,553.45	5,987,869,425.37
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,646,696,553.45	5,877,869,425.37
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	-	110,000,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,795,986,698.93)	(4,567,702,703.18)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	154,889,662.41	6,076,893.52
	Бусад	154,889,662.41	6,076,893.52
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	771,400,198.37	2,894,895,433.40
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,119,914.50	2,125,197,844.88
	Төлсөн ногдол ашиг	748,919,700.00	756,391,290.00
	Бусад	21,360,583.87	13,306,298.52
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(616,510,535.96)	(2,888,818,539.88)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	4,244,392,736.88	(228,197,163.02)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,732,492,650.22	12,976,885,387.10
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,976,885,387.10	12,748,688,224.08

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.5 ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016		2017		
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Нийт орлого	сая.төг	32,642.8	33,670.0	34,654.5	35,465.5	102.3
2	Үүнээс: Сувгийн түрээс	сая.төг		16,423.3	14,774.7	15,581.1	105.5
	Улс хоорондын сүлжээ	сая.төг	-	2,261.5	4,469.2	3,371.2	75.4
	Худаг сувагчлал	сая.төг		3,531.8	3,502.4	3,676.4	105.0
	Байр талбай, антенн түрээс	сая.төг		7,086.9	7,466.5	7,488.3	100.3
	Хэрэглэгчийн шугам	сая.төг		1,569.9	1,443.3	1,524.0	105.6
	Техник менежмент	сая.төг		1,772.1	2,169.6	2,305.2	106.3
	Үйл ажиллагааны бус орлого	сая.төг		1,024.6	828.7	1,519.2	183.3
3	Нийт зардал	сая.төг	30,978.4	30,630.1	32,652.5	32,907.9	100.8
5	Татварын өмнөх ашиг, алдагдал	сая.төг	1,378.6	3,093.0	2,002.0	2,557.6	127.8
6	Цэвэр ашиг, алдагдал	сая.төг	1,240.7	2,521.3	1,701.8	2,147.0	126.2
7	Борлуулалтын 1₮-т ноогдох зардал	төгрөг	0.96	0.91	0.94	0.93	98.5
8	Төсвийн нийт төлбөр	сая.төг	6,152.2	8,310.7	7,123.3	8,275.0	116.2
9	Үүнээс: Ноогдол ашиг	сая.төг	496.3	748.9	748.9	756.4	101.0
10	Нийт ажиллагсдын тоо	Хүн	1,100.0	1100.0	1100.0	1100.0	100.0
11	Цалингийн сан	сая.төг	7,551.5	7,563.0	8,006.5	7,985.4	97.3
12	Хөрөнгө оруулалт	сая.төг	8,017.4	3,352.8	12,181.2	11,851.5	97.3
13	Зээлийн төлбөр	сая.төг	-	-	2,124.1	2,125.2	-
14	Нийт авлага	сая.төг	4,500.0	4,292.3	4,653.0	4,114.2	88.4
15	Нийт өглөг	сая.төг	55,065.5	8,310.7	7,123.3	8,275.0	116.2
16	Үүнээс: Богино хугацаат өглөг	сая.төг	896.4	730.9	692.6	1,013.6	146.3
17	Шилэн кабелийн гэмтэл	Хувь	99.8	99.9	99.9	99.98	100.1
18	Шилэн кабелийн урсгал ашиглалтын хувь	Хувь	85.0	85.0	85.0	85.0	100.0
19	100 цэгт ногдох гэмтэл /зэс кабель/	цэг	8.0	7.0			

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**